

**2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
АУДИТААС ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, АЛБАН ШААРДЛАГА,
ТӨЛБӨРИЙН АКТЫН МӨРӨӨР ХИЙСЭН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр

Д/д	Өгсөн зөвлөмж	Гүйцэтгэл
1	Сургалтын тайлан, гүйцэтгэл дутуу анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийсэн. (Дорноговь салбар 19.0 сая төгрөг, Говьсүмбэр салбар 3.0 сая төгрөг)	- Дорноговь ЦТССалбар “Нью Даймонд виннерс” ХХК-тай 2024.12.16 -ны өдөр 5.0 сая төгрөгийн сургалтын гэрээ байгуулсан. Сургалтын тайлангийн гүйцэтгэл (9 хуудас), “Гүехэн далай” ХХК-тай 2024.12.12 -ны өдөр 14.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 50 кВт чадалтай инвертер худалдан авсан. Дутуу байсан анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн. (28 хуудас), - Говьсүмбэр ЦТССалбар нь сургалт хийсэн газартай холбогдох гэрээг нөхөн хийж анхан шатны баримт бүрдэлтийг бүрэн бүрдүүлж ажилласан. Гэрээг хавсаргав. Цаашид анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллах болно.
2	Сэлбэг, аюулгүй байдлын хөрөнгө хадгалах агуулахгүйгээс 790.0 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан. (Төв компани)	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Гадна агуулах барих” ажлын зураг хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна. 2026 оны хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөнд барилга угсралтын ажлыг төлөвлөн гүйцэтгүүлэхээр тооцон ажиллаж байгаа.
3	Контент хийлгэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний үүргийн гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд хангуулаагүй.	- Эрчим хүчний хэмнэлттэй, үр ашигтай зохистой хэрэглээний дадал зуршлыг бий болгох, эрчим хүчний тухай хуулийг сурталчлах зорилготой видео шtroкыг “Шинэшаяне” ХХК-аар, №АГГ/24-01 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх үед мэргэжлийн хэллэг зөрүүтэй, дуу, дүрсний нийлэмжгүй хэсгүүд гарч засварлуулах шаардлага тавьж, хугацаанд нь хүлээж аваагүй болно. - Тус “Шинэшаяне” ХХК-аар дээрх зөрчлүүдийг арилгуулан видео шторкуудыг хүлээн авч, 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдөр гэрээг дүгнэсэн акт үйлдсэн. Гэрээ дүгнэсэн акт, гэрээний гүйцэтгэлийг 2024 онд хяналт шалгалт хийсэн Нийслэлийн төрийн аудитын хяналтын хэсэгт шалгуулсан болно.
4	Тайлант онд ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрт байршуулсан 343.3 сая төгрөгийн компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад	2025 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан НТШ№25/23 дугаартай “Компьютер, мэдээлэл технологийн тоног төхөөрөмж бусад дагалдах хэрэгслийн

	дагалдах хэрэгслийг өөрийн байгууллага дээр худалдан авах ажиллагааг зохион байгуулж худалдан авсан.	хамт” тендерийг тусад нь багцлан компьютер болон принтерийг ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа.
Д/д	Өгсөн албан шаардлага	Гүйцэтгэл
1	Спортын арга хэмжээнд нийт 197.3 сая төгрөгийг төлөвлөснөөс 19.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан.	Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар Төлөвлөлт, маркетинг хариуцсан менежер хяналт тавьж Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Төлөвлөлт эдийн засгийн хэлтсийн дарга нарт анхаарч ажиллах чиглэл өгөөд ажиллаж байгаа.
2	Тайлант онд шинээр авсан Ланд круйзер LC78 маркын автомашиныг ашиглах боломжгүй нөхцөл үүссэн боловч даатгалаас болон бусад байдлаар хохирол барагдуулах арга хэмжээ аваагүй байна. (Говьсүмбэр салбар)	Салбарын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Ланд круйзер LC78 маркийн тээврийн хэрэгслийг 05 дугаар сарын 13-ны өдөр “Амка Бет Сервис” ХХК-ны засварт өгч засварлах ажил зохион байгуулан ажилласан. Тухайн засварын ажил 07 дугаар сарын 23-ны өдөр дуусаж, авто тээврийн улсын хяналтын үзлэг оношилгоонд хамруулж холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тухайн тээврийн хэрэгслийг засварлахад засварын хөлсөнд 15 сая төгрөг, шаардлагатай сэлбэг хэрэгсэлд 14.7 сая төгрөг нийт 29.7 сая төгрөгийн зардал гаргасан болно. Тухайн тээврийн хэрэгсэлтэй холбоотой бичиг баримтын бүрдэл шаардлага хангахгүйн улмаас даатгалын газраас төлбөр төлөгдөөгүй хувийн зардлаар засварын төлбөрийг бүрэн барагдуулсан. Одоогоор салбарын үйл ажиллагаанд хэвийн явж байна.
3	Байгууллагын үндсэн ажилтны хувийн компаниас шууд худалдан авалт хийсэн. (Говьсүмбэр салбар)	- Компанийн гүйцэтгэх захирлын 2025.01.28-ны өдрийн 01/87 тоот албан бичгийн дагуу Худалдан авах төлөвлөгөөнд заасан нийт 4 ажлын 61.5 сая төгрөгийн худалдан авах эрх шилжиж ирсэн. Тус эрхийн дагуу төсөвт өртөгт багтаан худалдан авах үнийн санал хүргүүлсэн. Дараах 4 газартай гэрээ байгуулан хамтран ажилласан. “Мөнх үйлс буудай” ХХК-тай ШХАН№25/09 дугаар бүхий 16,480.0 мянган төгрөгийн авто машины сэлбэг, “Цэгээн чоно” ХХК-тай ШХАН№25/14 дугаар бүхий 13,780.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлын материал, “Гэрэлт шугам” ХХК-тай ШХАН№25/25 дугаар бүхий 12,253.0 мянган төгрөгийн борлуулалтын ашиглалтын түвшин дээшлүүлэх өвлийн бэлтгэл хангах ажлын материал, “ОСО” ХХК-тай ШХАН№25/18 дугаар бүхий 7,820.0 мянган төгрөгийн ашиглалтын түвшин дээшлүүлэх ажлын материал худалдан авах гэрээг тус тус байгуулан

		ажилласан. Гэрээний дагуу гэрээ дүгнэж ажлын материал хүлээн авах акт, нэхэмжлэл, е-баримт зэрэг анхан шатны баримтыг бүрдүүлж, нийт төсөвт өртгөөс хэтрүүлэлгүй ажилласан. Холбогдох гэрээг эх хувиар компанийн ХАХХэлтэст хүргүүлэн ажилласан байна.
4	Байдлаг дэд станц, Луус дэд станцын хашаа барих ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэслэлгүйгээр анх батлагдсан тоо хэмжээг бууруулсан ч төсөвт өртгийг бууруулалгүй анхны батлагдсан төсөвт өтгөөр худалдан авалт зохион байгуулсан. Тендерийн баримт бичиг боловсруулахдаа ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичгийг ашиглаагүй. Бараа материал худалдан авах тендерийн жишиг баримт бичгийг ашиглан тендерийг зохион байгуулсан.4	2025 оны худалдан авалтын төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар худалдан авах 61 нэр төрөл бүхий тендер байгаагаас 30 нээлттэй тендер шалгаруулалтын арга, 31 харьцуулалтын аргаар худалдан авах тендер байна. Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах 28 нэр төрөл бүхий тендер, харьцуулалтын аргаар худалдан авах 31 нэр төрөл бүхий тендерийг хуулийн зөвлөх болон хяналт хариуцсан менежерээр хянуулж тендер шалгаруулалт зарлагдсан. Хянуулаагүй үлдсэн 2 тендер нь зарлагдаагүй бөгөөд 2025 онд худалдан авалт хийгдэх шаардлагагүй болсон болно.
5	Тэвштэй авто краны тендерт шалгаруулсан компани нь үйл ажиллагааны чиглэл нь тохирохгүй, ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага байхгүй. Тендерийн баримт бичигт ижил төрлийн гэрээний мэдээлэл ирүүлэх тухай үнэлгээний хороо заагаагүй. Тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулсан тухай үнэлгээний хороо нь хуралдаж шийдвэрлээгүй.	2025 оны худалдан авалтын бүх тендерт АЗ-ын сургалтад хамрагдсан гэрчилгээ авсан компанийн ажилчид, хөндлөнгийн гишүүн бүхий хүмүүсээр үнэлгээний хорооны тушаал гаргуулан томилж ажиллаж байна.
6	Эрүүл монгол хөтөлбөртэй давхардуулж үйл ажиллагааны чиглэл тодорхой бус компанитай гэрээ байгуулан ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан, төсвийг үрэлгэн зарцуулсан.	Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/56 дугаартай тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл, Үйлдвэрчний эвлэлтэй хамтран ажилчдын эрүүл мэндийн үзлэгийг үр дүнтэй зохион байгуулах талаар хуралдаж дараах шийдвэрийг гаргаж, Худалдан авах ажиллагаа, хангамжийн албанд хүргүүлсэн. Үүнд: ХАА-ны төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар тендер зарлахаар тусгагдсан тул тус тендерт оролцох урилгыг сайн эмч нартай Хавдар судлал, 2-р эмнэлэг, Япон-

		Монголын эмнэлэг, Ачтан, Бриллиант зэрэг эмнэлгүүдэд албан бичгээр нийт 6 эмнэлэгт урилга хүргүүлсэн. 2025 оны НТШ№25/21 дугаартай “Эрүүл мэндийн үзлэг” нь энэ онд хоёр зарлагдаж амжилтгүй болсон. Бүх хууль дүрмийг баримтлан дахин зарлагдана.
Д/д	Төлбөрийн акт	Гүйцэтгэл
1	Тайлант онд дүрэмт хувцас худалдан авах ажлыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж худалдан авсан.	- Төлбөрийн актаар 27,234,000.00 (Хорин долоон сая хоёр зуун гучин дөрвөн мянга) төгрөгийг “Нийслэл дэх төрийн аудит”-ын газрын 100200000908 тоот дансанд 2025 оны 4-р сарын 24-ний өдөр шилжүүлсэн. - Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх талаар Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны албан чиглэл өгч ажиллаж байна. 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан 13 ширхэг дүрэмт хувцсыг хасаж, дүрэмт хувцас захиалсан ажилтнуудад ажлын тусгай хувцас олгохоор шийдвэрлэсэн.

Хянасан:

Гүйцэтгэх захирал

Гүйцэтгэл гаргасан:

Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга,
ерөнхий нягтлан бодогч

Х.Ганчулуун

Т.Болдсанаа ~